



НИЙСЛЭЛИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТОГТООЛ

2024 оны 06 сарын 13 өдөр

Дугаар 83

Улаанбаатар хот

Төлөөлөн удирдах зөвлөлийн
гишүүдийг чөлөөлж, томилох тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль 35 дугаар зүйлийн 35.1.11 дэх заалт, 35.1.12 дахь заалт, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн 77.4 дэх зүйл, Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.7 дахь заалт, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 54 дүгээр тогтоолоор батлагдсан “Удирдах зөвлөлийн ажиллах журам”-ын 2.1, “Нийслэлийн өмчийн оролцоотой хувь нийлүүлсэн хуулийн этгээдэд төлөөлөл хэрэгжүүлэх журам”-ын 2.1 дэх заалтыг тус тус үндэслэн Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас ТОГТООХ нь:

1. “Төв цэнгэлдэх хүрээлэн” ХХК-ийн төлөөлөн удирдах зөвлөл гишүүдийг хавсралт ёсоор чөлөөлж, томилсугай.

2. Томилогдсон гишүүдэд Компанийн тухай хууль, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 54 дүгээр тогтоолоор батлагдсан “Удирдах зөвлөлийн ажиллах журам”, “Нийслэлийн өмчийн оролцоотой хувь нийлүүлсэн хуулийн этгээдэд төлөөлөл хэрэгжүүлэх журам” болон холбогдох бусад хууль, тогтоомжийг мөрдөн ажиллахыг даалгасугай.

3. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хурлын Засаглал, эрх зүйн шинэтгэлийн хороо (Н.Баярчимэг)-нд даалгасугай.

ДАРГА



Ж.БАТБАЯСГАЛАН

Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын
2024 оны 06 дугаар сарын 13-ны өдрийн
.83.. дугаар тогтоолын хавсралт

**“ТӨВ ЦЭНГЭЛДЭХ ХҮРЭЭЛЭН” ХХК-ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ
ЗӨВЛӨЛИЙН БҮРЭЛДЭХҮҮНЭЭС ЧӨЛӨӨЛЖ, ТОМИЛОХ ГИШҮҮДИЙН НЭРС**

№	Хуулийн этгээдийн нэрс	Чөлөөлөгдөх гишүүдийн нэрс	Томилогдох гишүүний нэр	Одоо эрхэлж буй албан тушаал
1	“Төв цэнгэлдэх хүрээлэн” ХХК		Б.Батбямба	Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын нарийн бичгийн дарга бөгөөд Ажлын албаны дарга
2		Т.Нямдаваа	Д.Амгалан	Нийслэлийн ЗДТГ-ын Хууль тогтоомж, гэрээ, эрх зүйн газрын дарга
3		Т.Нямдаваа	П.Хадбаатар	Нийслэлийн ЗДТГ-ын Нийслэлийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга
4		Н.Булганбаатар	Г.Баярцэцэг	Нийслэлийн ЗДТГ-ын Төрийн захиргааны удирдлагын газрын Хэвлэл, мэдээлэл, олон нийттэй харилцах хэлтсийн дарга
5		Ж.Сүхбаатар	Э.Хаш-Эрдэнэ	E-mongolia академийн олон нийттэй харилцах газрын дарга
6		Н.Хашцэцэг	Б.Адъяа	Нийслэлийн Өмчийн харилцааны газрын өмчийн менежментийн хэлтсийн ахлах мэргэжилтэн